

Enkhjargal Oyunbadam (Mongolia)

Хүндэт ноён хурлын даргаа.

Эрхэм зочид, төлөөлөгчид, ноёд, хатагтай нараа.

Дэлхийн өнцөг булан бүрээс оюун санаа,энх амгалангийн элч төлөөлөл болон ирсэн та бүхэнд ази тивийн зүрхэнд орших эртний түүхт Монголын ард түмний мэндийг уламжилъя.

Энэхүү хурлыг зохион байгуулж, хөх тэнгэр, хөрст газар нэгтэй хүн төрөлхтний элч төлөөлөгчдийг уулзуулан үзэл бодол ,үйлс зорилгоо хуваалцах боломж бүрдүүлэхийн тулд сэтгэл зүтгэлээ зориулж буй та бүхэнд талархлаан илэрхийлж ,хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Монгол улс төрт ёсны олон мянган жилийн түүхтэй, евроазийн нүүдэлчдийн соёл уламжлалын голомт болсон орон гэдгийг та бүхэн мэдэх бизээ. Өдгөө ч бид байгаль экологийн хувьд ариун дагшинаараа байгаа уудам тал хээр,хангай говь хосолсон нутагтаа түүх уламжлалаа хадгалан оршоор байна. Түүхэн цаг үеүдэд төрийн тогтолцоо,үзэл суртал өөрчлөгдөж байсан авч 1990 оноос чөлөөт эдийн засаг,парламентийн засаглал бүхий ардчилсан орон болсон. Хүн амын ихэнх хувь нь Буддын шашин шүтдэг төдийгүй эртний нүүдэлчдийн соёл уламжлалын өв бөөгийн шашныг тодорхой хэсэг нь шүтдэг юм. 1990 оноос Монгол орон улс төр эдийн засгийн хувьд нээлттэй орон болж олон ургальч үзэл дэлгэрсэнээр бусад шашны урсгал чиглэл орж ирэх болсон. Чухам эндээс үзэхэд манай улсыг хэдийгээр цөөн хүн амтай улс боловч олон шашны урсгал дэлгэрч буй орон гэж үзэж болох юм.

Монгол улсад 1990 онд ардчилсан хувьсгал ялснаар аливаа хүнийг үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэгээр нь ялгаварлан үзэх явдал нэгэнт үеэ өнгөрөөж хүний эрх,эрх чөлөөг хууль эрх зүйн хүрээнд баталжуулсан юм.

**Шинэ үндсэн хуулинд:**“Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” хэмээн заасан бөгөөд төр, шашны харилцааны асуудлыг “Монгол Улсын Үндсэн Хууль” (1992), “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль” (1993), “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (1994), “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль” зэрэг хууль эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулах болсон юм. Эдгээр баримт бичгүүд нь ардчилсан үзэл

баримтлал бүхий манай улсын төрөөс шашны тухайд баримтлах бодлогын чиг хандлагыг тодорхойлсоор ирлээ.

Монгол Улсын Үндсэн хуулинд “Хүнийг шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”, “Монгол улсын иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаатай эдлэх бөгөөд иймээс онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хүний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуулиар хязгаарлаж болохгүй “гэж заасан юм.

Хүний шүтэх эс шүтэх эрх чөлөөг ийнхүү баталгаажуулахын зэрэгцээ “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь гадаад, дотоод хэмээн ангилж, II зүйлийн 22-р хэсэгт Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүдийн нэгэнд “шашин үндэс угсаа, нутаг орны хурц маргаан, зөрөлдөөн гарах нөхцөл байдал бий болох” хэмээн тодорхойлж улс орныхоо аюулгүй байдлыг аливаа шашнаас ангид дээдлэн үзсэн билээ.

**1993 онд Төр сүм хийдийн харилцааны тухай хууль батлагдсан. Өнгөрсөн 17 жилийн хугацаанд манай орны шашны нөхцөл байдалд олон өөрчлөлтүүд бий болсон нь шашны эрх зүйн зохицуулалтыг өөрчилж, шинэчлэхийг шаардаж байна. Цаашид шашин, сүм хийдийн асуудлыг зохицуулсан хуулийг шинэчлэн боловсронгуй болгох, шашин хоорондын асуудлыг зохицуулах бүтцийг төрийн тогтолцоонд бий болгох зэрэг асуудлууд манай оронд тулгамдаж байгаа юм. Өнөөдрийн өндөрлөгөөс харах юм бол амьдралд нийцээгүй, хөгжлийн хурдыг гүйцээгүй зүйлс нилээд байна. Монголын төр засаг шашны зүтгэлтнүүдийн хамтаар санаагаа нэгтгэн хуулийг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдан парламентийн төвшинд ажиллаж байна.**

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын ҮШ зүйлийн “Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал”-ын хэсэгт “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэж, шашин-сүм хийдийн дотоод хэрэгт төрөөс үл оролцон, жаяг номын нь дагуу чөлөөтэй явуулах,” “Шашин хоорондын харилцааны асуудлыг төрийн онцгой анхааралд байлгаж, хямрал мөргөлдөөнөөс сэргийлэх. Аливаа сүм хийдийн үйл ажиллагааг үндэсний соёл иргэншилд хор хохирол үл учруулах хэмжээнд хууль зүйн хүрээнд байлгах” нь соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах арга замын нэг болохыг тодорхойлсон байна.

Төр,сүм хийдийн харилцааны тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулиар зарлан тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулахад оршино. Уг хуульд:

1. Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна.
2. Иргэнийг шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.
3. Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
4. Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг гагцхүү бусад иргэний мөнхүү эрх чөлөө, эрүүл мэнд, ёс суртахуун болон үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг тогтон зохицуулж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээр зохицуулан хэрэгжүүлнэ.
5. Иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгахыг хориглоно. гэж заасан нь чухамдаа Монголын төрөөс шашин,иргэн хоорондын харилцааны талаар баримталж байгаа бодлогын илрэл юм.

**Энэ мэтээр улс орон бүхэн улс төр,эдийн засаг,засаглалын хэлбэрээсээ үл хамааран төрөөс шашны талаар баримтлах бодлого,эрх зүйн орчин бүрдүүлэх нь даяаршлын үед бүр ч чухаг байгаа билээ. Харин Шинэ зуун, шинэ нөхцөл байдалд ямар шашин шүтдэгээс үл хамааран нэгэн дэлхийд амьдардаг учир шалтгааны улмаас хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй асуудлын хувьд нэг болоод байна.**

Энэ бол хүн төрөлхтний ирээдүйн төлөв байдлыг тодорхойлж буй байгаль экологийн хямрал юм. Өнөөдөр энэ танхимд хуран чуулсан эрхэм төлөөлөгчид шашны олон урсгал чиглэлийн зүтгэлтнүүд та бүхэнд Хүний нийгмийн түүхийн турш биднийг асар их хүчээр өөртөө татаж ирсэн шашин хэмээх энэ хүчит оюун санааны нөлөөллийг Дэлхийн ертөнцөө авран хамгаалах,энэрэнгүй үйлсэд чиглүүлж хамтран ажиллахыг уриалж байна. Аливаа шашин улс үндэстэний онцлогийг хадгалан номлол сургаалаар өөр өөр боловч оршин бүхий ертөнцийг хайрлан энэрэхүй үзэл санаагааар нэг зорилгод нэгдэж чадна хэмээн бодож байна. Хайр энэрэл дутаж буй эх дэлхийнхээ төлөө бүхий л шашин бүхэн нэгдэж хамтран ажиллах цаг нэгэнт болжээ.

Энэ их энэрэнгүй үйлсэд хамгийн түрүүнд өөр өөрсдийн хүн ардаа нөлөө бүхий энэрэнгүй үзэлтэн шашны, хуулийн, улс төрийн зүтгэлтэнгүүд та бүхнийг оройлон зүтгэхийг уриалж байна.

**Анхаарал тавьсанд Баярлалаа.**